

Маргааны товч

Ашигт малтмал газрын тосны газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 02 дугаар шийдвэрээр “Хуульд заасан хугацаанд тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг алдангийн хамт бүрэн төлөөгүй” гэх үндэслэлээр нэхэмжлэгч “Солид трейд” ХХК-ийн Баянхонгор аймгийн Баянговь сумын “Бор нуруу” гэх талбайн XV-021146 дугаартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцалжээ.

Нэхэмжлэгчээс “... шинэ нотлох баримт буюу тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон тухай албан бичгийг хүргүүлээгүй, хаягийн өөрчлөлтийг дурын этгээд гаргах боломжгүй, захиргааны байгууллага гарын үсэг зурж баталгаажуулдаг” гэх зэргээр хүсэлт гаргажээ.